



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Уртын гэгээ ОНӨААТҮГ-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2022/16/НА-СТА-ОНА

Цахим хуудас:
www.audit.mn
Баруун-Урт сум
2022 он

Дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Утас: 99029193 Цахим хаяг: narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Даваа
Утас: 99035990 Цахим хаяг: davaag@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Ариунбаяр
Утас: 99076224 Цахим хаяг: ariunbayars@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн орлогын тайлан	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
3. Аудитын тайлан	7
3.1 Ерөнхий зүйл	7
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	7
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	7
3.4 Материаллаг байдал	8
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	8
Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	8
3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	8
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	10
3.8 Аудитын гол асуудал	10
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	10
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	10
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	11
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	11
4. Аудитын илрүүлэлт	11
4.1 Запруулсан алдаа	11
4.2 Төлбөрийн акт	11
4.3 Албан шаардлага	12
4.4 Зөвлөмж	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	13
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НБББББ	Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Баримт Бичиг
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НӨАТ	Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар
ОНӨААТҮГ	Орон Нутгийн Өмчит Аж Ахуйн Тооцоотой Үйлдвэрийн Газар
СТА	Санхүүгийн Тайлангийн Аудит
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани



**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

СҮХБААТАР АЙМГИЙН УРТЫН ГЭГЭЭ
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА Н.ЭНХЖАРГАЛ
ТАНАА

2022.03.16 № 137
танай _____-ны № _____-т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Уртын гэгээ ОНӨААТҮГ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Уртын гэгээ ОНӨААТҮГ-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовн ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Албан хаагчдад төрд алба хаасан хугацааны нэмэгдэл олгосон, цалингийн урьдчилгааг суутгаагүй, харилцагч байгууллагад материалын үнэ илүү шилжүүлж зардалд илэрхийлсэн, жолоочийн тооцооны хуудсыг үнэн зөв илэрхийлээгүй, материалын үлдэгдлийг зарлагадсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, тайлант хугацааны ажил гүйлгээний анги, дансны үлдэгдлийн холбогдох тодруулгын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, тасалбар болголт, оршин байх, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

(2021 оны 12 сарын 31 –ны өдрөөр дуусгавар болсон)

төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	10,521,409	26,769.10
1.1.2	Хувь хүмүүсээс авах авлага	24,002	324,002
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	12,212,067	24,891,488.70
1.1.4	Бусад авлага	12,906,935	2,132,162.87
1.1.6	Хангамжийн материал	16,262,000	16,931,069.00
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо		24,856,640.00
1.1.8	Бусад эргэлтийн хөрөнгө		51,350,000.00
1.1.11.	Эргэлтийн хөрөнгийн дүн	51,926,412	120,512,131.67
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Барилга байгууламж	3,438,653,635	4,443,839,723.10
1.2.2	Хуримтлагдсан элэгдэл	(1,525,125,240)	(1,763,893,704)
1.2.3	Авто тээврийн хэрэгсэл	77,600,000	222,272,222
1.2.4	Хуримтлагдсан элэгдэл	(36,682,199)	(44,442,199)
1.2.5	Машин тоног төхөөрөмж компьютер	2,572,780	6,661,480
1.2.6	Хуримтлагдсан элэгдэл	(257,278)	(1,391,981)
1.2.7	Тавилга эд хогшил	1,694,000	1,879,000
1.2.8	Хуримтлагдсан элэгдэл	(169,400)	(338,800)
1.2.9	Бусад үндсэн хөрөнгө	519,065	519,065
1.2.10	Биет бус хөрөнгө	420,000	420,000
1.2.10.	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	1,959,225,363.53	2,865,524,806.94
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,011,151,775.76	2,986,036,938.61
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.3	Орлогын татварын өглөг	1,751,402	
2.1.1.4	Байгууллагад төлөх өглөг		12,155,446
2.1.1.6	Хувь хүнд төлөх өглөг		273,356.60
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	2,058,434,088	3,216,789,051.2
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	2,060,185,490	3,229,217,853.80
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		0
2.2.	Өр төлбөрийн нийт дүн	2,060,185,489.68	3,229,217,854
2.3	Эздийн өмч		
	Өмнөх үеийн	(16,562,434.24)	(49,033,713.92)
2.3.10.	Тайлангийн үеийн	(32,471,279.68)	(194,147,201.27)
2.3.11.	Эзэмшигчдийн өмчийн дүн	(49,033,713.92)	(243,180,915.19)
2.5.20	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,011,151,775.76	2,986,036,938.61

2.2 Аудит хийсэн орлогын тайлан

(2021 оны 12 сарын 31 –ны өдрөөр дуусгавар болсон)

төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	655,296,401.64
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	575,944,109.64
11	ТАТВАРЫН ОРЛОГО	432,574,109.64
110	Орлогын албан татвар	
1100	Засгийн газрын олгох санхүүжилтийн орлого	432,574,109.64
110002	Үйл ажиллагааны бус орлого	79,352,292.00
110004	Бусад орлого санхүүгийн холбоотой түрээс бусад	2,870,000.00
110005	Үйл ажиллагаа үйлчилгээний орлого	140,500,000.00
3	Нийт ашиг (алдагдал)	143,370,000
9	Борлуулалт, маркетингийн зардал	0
10	Ерөнхий ба удирдлагын зардал	849,443,602.91
11	Санхүүгийн зардал	
12	Бусад зардал	0
17	Бусад ашиг (алдагдал)	0
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(194,147,201.27)
19	Орлогын татварын зардал	
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(194,147,201.27)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(194,147,201.27)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0
24	Орлогын нийт дүн	(194,147,201.27)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(2021 оны 12 сарын 31 –ны өдрөөр дуусгавар болсон)

төгрөгөөр

	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
9	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	0			(49,033,713.92)	(49,033,713.92)
11	Залруулсан үлдэгдэл					
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(194,147,201.27)	(194,147,201.27)
17	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	0	0	0	(243,180,915.19)	(243,180,915.19)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(2021 оны 12 сарын 31 –ны өдрөөр дуусгавар болсон)

төгрөгөөр

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Тайлант жилийн дүн
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
1.1	<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	588,154,500.00
	Татаас, санхүүжилтийн орлого	432,574,109.64
	Бусад мөнгөн орлого	155,580,390.36
1.2	<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	594,954,439.83
	Ажиллагчдад төлсөн	157,209,139.00
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	46,621,884.43
	Бараа материал худалдан авахад төлсөн	254,219,444.00
	Ашиглалтын зардалд төлсөн	44,235,751.00
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	29,756,252.00
	бичиг хэргийн зардал	3,425,110.00
	Татварын байгууллагад төлсөн	12,676,021.40
	шуудан холбооны зардал	669,622.00
	Даатгалын төлбөрт төлсөн	136,125.00
	Бусад мөнгөн зарлага	46,005,091.00
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	
2.1	<u>Мөнгөн орлогын дүн (+)</u>	0.00
2.2	<u>Мөнгөн зарлагын дүн (-)</u>	
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	3,694,700.00
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	
	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(6,799,939.83)
2.3.	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,694,700.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(10,494,639.83)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,521,408.93
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	26,769.10

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Уртын гэгээ ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгадагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Ариунбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Уртын гэгээ ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлангаа Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Хотын нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайг гэрэл гэгээгээр тасралтгүй хангах, иргэдийн сэтгэл ханамжийн баталгааг бүрэн хангах, оршин суугчдын ая тухтай, цэвэр орчинд амьдрах нөхцөлийг бүрүүлэх гэсэн дэд зорилт дэвшүүлсэн байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус компани нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж батлуулаагүй бөгөөд ижил төстэй байгууллагуудын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хуулбарлан үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Уртын гэгээ ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 849,443.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 8,494.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 5,946.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Байгууллагын үйл ажиллагаа

Уртын гэгээ ОНӨААТҮГ нь хотын нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн гэрэлтүүлгийн тасралтгүй байдлыг хангах, иргэдийн сэтгэл ханамжийн баталгааг бүрэн хангах, оршин суугчдыг цэвэр орчинд ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилготой үйл ажиллагаагаа явуулж байна.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд гэрэлтүүлэг засвар үйлчилгээ, зам талбай, хөшөө дурсгал, тоглоомын талбайн арчлалт, хамгаалалт, иргэдийн үйлчилгээ гэсэн статустай байна. Өмчийг 100 хувь орон нутаг эзэмшиж байна.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Талын зам ТӨХК нь Баруун-Урт сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 07 сарын 23-ны 18 тоот тогтоолоор “Уртын гэгээ” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар /ОНӨААТҮГ/ нэртэйгээр байгуулагдаж, 2019 оны 1 сарын 1-ээс үйл ажиллагаа эхэлсэн. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дүгээр зүйлд “Орон нутгийн өмчийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь бүрэн эрхтэй: ... 5/ орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих;...” гэсэн заалттай нийцэж байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дээрх төрлийн зардлыг гаргаагүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.6 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Уртын гэгээ ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	10,521.4	26.8	(10,494.6)
Авлага	25,143.0	27,347.7	2,204.7
Урьдчилж төлсөн тооцоо		24,856.6	24,856.6
Бараа материал	16,262.0	68,281.1	52,019.1
Үндсэн хөрөнгө	1,958,805.4	2,865,104.8	906,299.4
Биет бус хөрөнгө	420.0	420.0	-
Нийт хөрөнгийн дүн	2,011,151.8	2,986,036.9	974,885.1
Богино хугацаат өглөг	1,751.4	12,428.8	10,677.4
Урьдчилж орсон орлого	2,058,434.1	3,216,789.0	1,158,354.9
Эздийн өмч	(49,033.7)	(243,180.9)	(194,147.2)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,011,151.8	2,986,036.9	974,885.1

Арилжааны банкин дахь харилцах дансанд байгаа мөнгөний үлдэгдэл 26.8 мянган төгрөг байна.

Авлага дансны үлдэгдэл өмнөх оноос 2,204.7 мянган төгрөгөөр өссөн байна. Тайлант онд Дөрвөлж ОНӨААТҮГ-аас нийтийн орон сууцны цэвэрлэгээ үйлчилгээтэй холбоотой авлага 10,774.8 мянган төгрөгөөр буурсан байна. харин НӨАТ-ын буцаан авалттай холбоотой үүссэн татварын авлага 12,679.4 мянган төгрөгөөр өссөн бол албан хаагчдад олгосон 300.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг суутган тооцоогүй авлагаар бүртгэсэн нь авлага өсөхөд нөлөөлсөн байна.

Урьдчилж гарсан тооцоо данс: Гудамж талбайн гэрэлтүүлгийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор БНХАУ-ын Эрээн хотоос материал татахаар 24,856.6 мянган төгрөгийг харилцагч байгууллагын дансанд шилжүүлсэн боловч ковид цар тахлын улмаас хил хаагдаж, тухайн материалыг тайлант онд хүлээн авах боломжгүй болсноос үүссэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 52,019.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь аж ахуйн зориулалттай бараа материал худалдан авсан, хүүхдийн тоглоомын талбайн засварын материал /хүүхдийн ком гулсуур, бялдаржуулах төхөөрөмж/ зэргийг зарцуулаагүй үлдэгдлээр илэрхийлжээ. Мөн аймгийн ИТХ-ын шийдвэрээр худалдан борлуулах зорилготой 11,850.0 мянган төгрөгийн авто машины 3 гаржийг материалын тайланд тусгасан зэрэг бараа материал данс өмнөх оноос өсөхөд нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 906,299.4 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант онд орон нутгийн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээнд тусгагдсаны дагуу 1,155,071.1 мянган төгрөгийн эко автобус, гудамжны гэрэлтүүлэг, авто кран, чулууны үйлдвэр зэргийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч данс бүртгэлд тусгасан нь нөлөөлжээ.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэлд 10,677.4 мянган төгрөгөөр өсжээ. Энэ нь тайлант онд үүссэн бэлтгэн нийлүүлэгчээс худалдан авсан барилгын засварын болон шатах тослох материалтай холбоотой үүсэн бөгөөд харилцагч байгууллагатай тооцоо нийлж өглөгийг баталгаажуулсан байна.

Урьдчилж орсон орлого данс өмнөх оноос 1,158,354.9 мянган төгрөгөөр өссөн бөгөөд энэ нь үнэ төлбөргүй үндсэн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан нь нөлөөлжээ.

3.6 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Уртын гэгээ ОНӨААТҮГ нь байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Уртын гэгээ ОНӨААТҮГ нь 2021 онд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 7 зорилт 52 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, Баруун-Урт сумын Засаг даргаар батлуулсан байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг гарган сумын ЗДТГ-ын газарт хүргүүлсэн байна.

Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зорилт арга хэмжээний хэрэгжилтийг тоймлон авч үзвэл:

- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн гэр хорооллын 84 цамхаг, байгууллагын өөрийн санаачилга хөрөнгөөр 32 гэрэлтүүлгийг шинээр тавьсан;
- Баруун-Урт сумын 1 багийн Ягаан 24, Жаргалан хотхоны 213, 27А, 52 айл, 48 айл гэх мэт байрнуудын орцны засварыг хийсэн;
- Нийтийн эзэмшлийн хашаа, цэцэрлэгт хүрээлэн, хүүхдийн тоглоомын талбай зэргийн арчилгаа, засвар үйлчилгээг тогтмол хэрэгжүүлсэн байна;

Баруун-Урт сумын ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 17 өдрийн 3/07 тогтоолоор Уртын гэгээ ОНӨААТҮГ-т 200,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор төлөвлөн баталсан байна. Харин ИТХ-ын 2021 оны 7/03 дугаар тогтоолоор баталсан төсвийн тодотголоор санхүүгийн дэмжлэгийг 373,284.8 мянган төгрөг болгон нэмэгдүүлсэн байна. Орон сууцны цэвэрлэгээ арчилгаа, засвар үйлчилгээнээс 161,424.0 мянган төгрөг оруулахаар тооцсоноос 140,500.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй.

3.8 Аудитын гол асуудал

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал ажиглагдаагүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу Уртын гэгээ ОНӨААТҮГ-ын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим сайтад 99 мэдээллийг хугацаанд нь 36 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна. Харин таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 17 зарлагын гүйлгээний 26,098.5 мянга, орлогын 24 гүйлгээний 319,458.4 мянга, өр төлбөрийн 12,155.4 мянга, авлагын 27023.6 мянган төгрөгийн мэдээллийг тус тус мэдээлээгүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байгаа боловч зарим мэдээллийг хангалтгүй байршуулсан гэж дүгнэлээ.

3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3,034.7 мянган төгрөгийн төлбөрийн акт, зөрчлийг арилгах 66,494.9 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн байна. Шалгагдагч байгууллага өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилтийг 2021 оны 18 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Уртын гэгээ ОНӨААТҮГ-ийн санхүүгийн тайланд тусгагдсан 4,443,839.7 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн эдийн засгийн ангиллын дагуу тоолж, тулган баталгаажуулах ажлыг төлөвлөв.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 135,141.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 93,686.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 935.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 29,373.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 11,146.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Бараа материалын сар бүрийн тайланг тулган шалгахад 8 дугаар сарын эцсийн үлдэгдлийг дараагийн сарын эхний үлдэгдэлд 1,183.7 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн;
2. Бэлтгэн нийлүүлэгчээс худалдан авсан 4,370.4 мянган төгрөгийн бараа материалыг тайланд орлого зарлагаар бүртгээгүй;
3. Агуулахад хадгалагдаж байгаа 4,540.0 мянган төгрөгийн материалыг зарлагадсан;
4. Тогоон төмөр констракшн ХХК-тай тооцоо нийлсэн актаар 1,000.0 мянган төгрөгийн өглөгийг илүү тусгасан;
5. Тайлант оны өглөгийг 3,240.0 мянган төгрөгөөр дутуу тусгасан;
6. Урьдчилж орсон орлогын тайлант жилийн элэгдлийн зардал 79,352.3 мянган төгрөгийг орлого үр дүнгийн тайланд илэрхийлээгүй зэрэг алдаа зөрчлийг анхан шатны баримт, НББОУС, дүрэм журамд нийцүүлэн тус тус залруулж данс, бүртгэлд тусгуулав.

4.2 Төлбөрийн акт

Барилгын материалын худалдан авалтыг бэлтгэн нийлүүлэгчийн төлбөрийн нэхэмжлэх, төлбөр тооцоог харьцуулан тулган баталгаажуулахад Хар чоно барилгын материалын дэлгүүрт 935.7 мянган төгрөгийг илүү шилжүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7¹, 20 дугаар зүйлийн 20.1.4², 20.2.6³-т заасныг зөрчиж үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоолоо.

¹ Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.

² хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажуулахгүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх;

4.3 Албан шаардлага

1. Тайлант онд зарим ажилчдад 4,482.2 мянган төгрөгийн төрд алба хаасан хугацааны нэмэгдлийг олгосон.
2. Худалдан авалтын НӨАТ-ын буцаан авалтын 24,891.5 мянган төгрөгийн авлагыг аймгийн Татварын хэлтэстэй тооцоо нийлээгүй данс бүртгэлд тусгасан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4⁴, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5⁵ дахь заалтыг зөрчиж, ажил гүйлгээний анги, дансны тодруулгын тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

3. Шилэн дансны цахим системд цалингаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 17 зарлагын гүйлгээний 26,098.5 мянга, орлогын 24 гүйлгээний 319,458.4 мянга, өр төлбөрийн 12,155.4 мянга, авлагын 27023.6 мянган төгрөгийн мэдээллийг тус тус мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.4⁶, 6.4.5⁷-т заасныг зөрчиж тохиолдсон байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаад албан шаардлага хүргүүлээ.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1 Урсгал зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд 11,146.0 мянган төгрөгийн шатах тослох материалын зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудсаар үнэн зөв бүртгэж тайлагнаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Жолоочийн тооцооны хуудсыг батлагдсан маягтын дагуу иж бүрэн, үнэн зөв хөтөлж, тооцоог бодож, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.5-д заасны дагуу холбогдох албан тушаалтан гарын үсэг зурж, баталгаажуулах;

2 Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Уртын гэгээ ОНӨААТҮГ нь байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх НБББББ-ийг боловсруулж батлуулаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэлийн хөтлөх НБББББ-ийг НББОУС, Сангийн яамнаас гаргасан жишиг бодлогын баримт бичигт нийлцүүлэн боловсруулан батлуулж, мөрдөж ажиллах.

3 Урьдчилж орсон орлого данстай холбоотой асуудал

³ эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;

⁴ үйлдвэрийн газрын захиргааны бүтцийг тогтоож, албан тушаалтныг томилох, чөлөөлөх, эрх бүхий байгууллагаас тогтоосон цалингийн бүдүүвч сангийн хэмжээнд багтаан цалинг тогтоох;

⁵ дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;

⁶ таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;

⁷ цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;

Илрүүлэлт: Өмнөх онуудын урьдчилж орсон орлогын /үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгө/ элэгдлийг тооцсон боловч орлого үр дүнгийн тайланд орлогоор хүлээн зөвшөөрсөн урьдчилж орсон орлогыг бууруулах бичилт хийгээгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өмнөх онуудад урьдчилж орсон орлогоор хүлээн зөвшөөрсөн үндсэн хөрөнгийг элэгдлийн зардлаар бууруулах бичилт хийж, өмнөх үеийн ашиг алдагдал, өмчийн өөрчлөлтийн тайланд залруулга хийх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 6 дугаар сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Уртын гэгээ ОНӨААТҮГ	11	135,141.8	6	93,686.4	1.	935.7	2	29,373.7	2	11,146.0
Дүн		11	135,141.8	6	93,686.4	1.	935.7	2	29,373.7	2	11,146.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Шилэн дансны мэдээлэл	1						1			
Дүн		12	135,141.8	6	93,686.4	1.	935.7	3	29,373.7	2	11,146.0
Нийт дүн											